

Я.Ариунболд- ДХИС-ийн Удирдлагын
академийн Хилийн удирдлага стратеги профессорын
багийн профессор, хурандаа
Г.Шинэбилэг-ДХИС-ийн удирдлагын академийн 8042 дугаар
дамжааны магистрант, хошууч

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХИЛИЙН ХАРУУЛЫН ДАРГЫН АЖЛЫН АЧААЛАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Товч агуулга: Хилийн харуул нь улсын хил хамгаалалт, албаны үйл ажиллагааг хилийн шугаман дээр зохион байгуулж бүрэлдэхүүн нь ээлжээр томилогдон үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ихэнх тохиолдолд 1 хилийн харуулд 2 харуулын дарга ээлжлэн үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь энгийн байгууллагын алба хаагчидтай харьцуулхад хэт их ачаалал бөгөөд хил хамгаалах байгууллагын бусад албан тушаалтантай харьцуулхад мөн л ачаалал их багсаа юм. Иймд хилийн харуулын дарга нарын ажлын ачааллыг багасгах зорилготой.

Түлхүүр үгс: Хил хамгаалах байгууллага, хилийн харуул, харуулын дарга, ажлын ачаалал, дүн шинжилгээ

Оршил: Монгол Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Хил хамгаалах байгууллагын анхдагч нэгж нь хилийн харуул бөгөөд түүнийг хилийн харуулын дарга удирддаг.

Хилийн харуулд хил хамгаалах, сургалт дадлага явуулах, сэтгэлзүй, соёл сурталчилгааны ажил зохион байгуулах, ар тал, зэвсэг, инженерийн зэрэг ажлыг цогц байдлаар уялдуулдаг.

Хилийн харуулын дарга бүрэн дунд боловсролтой байх шаардлага тавигддаг бөгөөд хилийн харуулд дээд боловсролтойгоос эхлээд огт боловсролгүй хугацаат цэргийн алба хаагчдыг удирддаг хариуцлагатай албан тушаал юм.

Улсын хилийн халдашгүй дархан байдал торгон хилийн шугаман дээр үүрэг гүйцэтгэж буй хилчдээс шууд хамаарна. Өнөөгийн байдлаар хилийн харуулын дарга нь харуул дээр бүх үйл ажиллагааг хариуцан хэт их ачаалалтай үүрэг хүлээж, удаан хугацаагаар ажиллаж байна. Энэ нь тэдний ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж шинээр сэтгэх бүтээх, ар гэрийн амьдарлаа дээшлүүлэх, сурах мэдлэг боловсролоо ахиулах, албан тушаал дэвших боломжийг багасгаж байна.

Иймд хилийн харуулын даргын ажлын ачааллыг буруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, харуулын дарга нарын мэдлэг боловсролоо ахиулах, албан тушаал дэвших зэрэг боломжийг хайн энэхүү сэдвийг судлаж байна.

Хил хамгаалах байгууллага, хилийн харуулын тухай ойлголт

Улсын хил хамгаалах байгууллага гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг хэлнэ¹;

Хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг

- 1 .Улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
- 2 .Улсын хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах;
- 3 .Монгол улсын олон улсын гэрээ, хэлэлцээрээр хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;
- 4 .Улсын хилийн шугам, тэмдэг, холбоосын байршлыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх;
- 5 .Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- 6 .Хилийн аливаа асуудлыг хууль зүйн дагуу шийдвэрлэх;
- 7 .Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлэх;

Хилийн харуулын үүсэл хөгжил. Хилийн харуулын үүсэл хөгжил Улсын хил хамгаалалт үүсч бий болсон цагаас буюу манай эрний өмнөх IV зуунаас өнөөг хүртэл уламжлагдан ирсэн хил хамгаалалтын үнэт баялгийн нэг нь хилийн харуул юм. Тэр үеийн хилийн харуулын онцлог болон үйл ажиллагааны талаар тодорхой зүйл одоо хир олдоогүй ч гэсэн хилийн харуул бодитойгоор байжээ гэдгийг доктор Г.Сүхбаатар 1980 онд бичсэн “Монголчуудын эртний өвөг” зохиолдоо баталсан байдаг. Хилийн харуул нь үеийн үед шинэ шинэ агуулгаар баяжиж хувьсан өөрчлөгдсөөр өнөөг хүрчээ.

Суман харуул, өрхийн гэр харуул, өртөө харуул, цагдаа харуул, хилийн пост, хилийн харуул гээд төрөл бүрийн нэрээр нэрлэгдэж түүндээ тохирсон үйл ажиллагаа явуулж байв².

Хилийн харуул. Улсын хилийн тодорхой хэсгийг байнга хамгаалах, тусгайлан өгөгдсөн үүргийг биелүүлэх зорилгоор зориулалтын дагуу төхөөрөмжилсөн байранд буюу хөдөлгөөнт журмаар байрлаж өөрөөсөө хилийн манаа томилон үүрэг гүйцэтгүүлж буй нэгжийг хилийн харуул гэнэ³.

Хилийн харуулын даргын ажлын ачаалалын өнөөгийн байдал

Монгол Улс 1.564.116м² газартай нутагтай, 8252.658 километр /хуурай газраар - 7351.6 километр, усаар - 901,058 километр/ улсын хилтэй. Улсын хилийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах, улсын хилийн шугамыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх чиг үүргийг Хил хамгаалах байгууллага хэрэгжүүлдэг билээ.

Дээрх үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Хил хамгаалах ерөнхий газар, хилийн отряд /анги/, хилийн застав /салбар/, хилийн харуул /нэгж/ тэдгээрээс

¹ Хил хамгаалалтын I дүрмийн 1 дүгээр хэсгийн 6 дахь заалт.

² П.Даш. Хилийн харуул. УБ.,1998 он 9 дэх тал.

³ Хил хамгаалалтын III дүрмийн 1 дүгээр хэсгийн 1 дэх заалт

хилийн манаа томилон улсын хилд үүрэг гүйцэтгүүлэх тогтолцоогоор хил хамгаалах үйл ажиллагаа явагддаг.

Хил хамгаалах байгууллагыг Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч, хилийн отрядыг отрядын дарга /ангийн захирагч/, хилийн заставын заставын дарга, хилийн харуулыг харуулын дарга, хилийн манааг манааны ахлагч нар тус тус удирдах бөгөөд шатлан захирах, захирагдах зарчмыг баримтална.

Хилийн харуулын дарга нь хил хамгаалах байгууллагын нэгжийг удирдан бие даан үүрэг гүйцэтгэн шийдвэр гаргаж улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамагаалж байдаг чухал хариуцлагатай албан тушаал юм.

Монгол улсад хилийн харуулын даргын албан тушаалын орон тооны хангалт 83.0 хувийн хангалттай байгаагаас Монгол Улс - ОХУ-ын хилд 82.4 хувь, Монгол Улс БНХАУ-ын хилд 83.7 хувийн хангалттай.

Хилийн харуулын дарга /Хил хамгаалах байгууллагад алба хаах ахлагч/-д бүрэн дунд боловсролтой байх шаардлага тавигддаг бөгөөд 6.9 хувь нь дээд, 90.6 хувь нь бүрэн /тусгай/ дунд, 2.4 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 61.6 хувь нь харуулын даргын дамжаанд суралцсан, 38.3 хувь нь харуулын даргын дамжаанд суралцаагүй байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар харуулын даргын албан тушаалаас офицерын албан тушаалд дэвшсэн 9 алба хаагч байна.

Хилийн харуулын дарга нарын удирдан үүрэг гүйцэтгэдэг хилийн харуулуудын 0.8 хувь нь сумын төвд, 99.1 хувь нь хөдөө хээр байралдаг.

Хил хамгаалах байгууллагад ахлагч нар нь гүйцэтгэх албан тушаалд ажилладаг ба тэдгээрээс зөвхөн хилийн харуулын даргын албан тушаал нь хилийн харуулыг удирдах, удирдлагаас өгсөн үүрэг тушаалыг биелүүлэх зарчмаар хосолсон албан үүрэг гүйцэтгэдэг чухал хариуцлагатай албан тушаал юм.

Хилийн харуулыг орон тоогоор хоёр харуулын дарга хариуцан ажиллаж хилийн засталаас нэг нэгээрээ ээлжлэн томилогдож хилийн харуулыг ахлан дунджаар 7-10 хоногийн хугацаатай үүрэг гүйцэтгэдэг энэ нь нэг харуулын дарга нэг сарын 20 хоногт нь хилийн харуулд ажиллаж гэр бүлээсээ хол байдаг.

Хилийн харуулын дарга нар дунджаар жилийн 30 хоног ээлжийн амралттай, 165 хоног хилийн харуулд, 85 хоног хилийн манаа, заставын жижүүрийн үүрэг гүйцэтгэлттэй, 85 хоногт хилийн манаа, жижүүрийн амралт, хичээл сургалт, уралдаан тэмцээн бусад ажилтай байдаг.

Энэ нь тус харуулын дарга жилийн 245 хоног гэр бүлээлээсээ тэр дундаа цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдээсээ 305 хоног тусдаа байна гэсэн үг юм.

Хилийн харуулын даргын үүрэг гүйцэтгэлт, албаны ачааллын өнөөгийн байдлын талаар авсан судалгаагаар харуулын дарга нарын 98.7 хувь нь ажлын ачаалал их, 1.3 хувь нь ажлын ачаалал дундаж гэж хариулсан байна. Иймд харуулын дарга нарын ажлын их ачааллыг бууруулах зайлшгүй шаардлагатай юм.

Ажлын ачаалал үүсэгч хүчин зүйлс хилийн харуулын дарга нарын ажлын ачаалалд хэрхэн нөлөөлж байгаа талаар хилийн харуулын дарга нар дараах байдлаар хариулжээ. Үүнд

Эдгээр хүчин зүйлсийг 100 хувь гэж үзвэл нэгэн хэвийн ажил 84.5 хувь, ажлын байраа алдхаас айх 72.3 хувь, ажиллах орчны нөхцөл муу 62.7 хувь, мэргэжлийн хэт өндөр шаардлага 86.6 хувь, хийх ажил ойлгомжгүй, тодорхойгүй 9.5 хувь, урт ажлын цаг, байнга илүү цагаар ажиллах 94.1 хувь, мэдээлэл солилцох боломжгүй 76.4 хувь, ажлын байрны уур амьсгал муу 8.7 хувь, төлөвлөөгүй ажлаас шалтгаалан ажиллах 35.7 хувь, ажлын байранд өсөж дэвших боломж тааруу 93.5 хувь, төлөвлөх боломжгүй ажлын цаг 58.3 хувь, удирдлагын ойлголт хандлага муу 12.7 хувь, хэт их ажил төлөвлөснөөс шалтгаалсан ачаалал 87.5 хувь нөлөөлнө.

Хилийн харуулын даргын ажлын ачааллыг бууруулахад анхаарах асуудал

Хилийн харуулын дарга нь хилийн харуулыг ахлан үүрэг гүйцэтгэхдээ хил хамгаалалт, сургалт, цэргийн албаны зохион байгуулалт, холбоо харилцан ажиллагаа, мэдээ мэдээлэл, бүрэлдэхүүний сэтгэл зүйн байдал, соёл олон нийтийн ажил, зэвсэг, сум галт хэрэглэл, техник хэрэгсэл, албаны амьтад, ар тал хангалт зэрэг бүхий л үйл ажиллагааг ахлах дарга нарын өмнө биечлэн хариуцан ажиллаж байна.

Энэ олон хариуцлагатай үүргийг бусдад шилжүүлэх, эсвэл өөр хүн зайнаас удирдах боломжгүй тул ийнхүү харуулын даргад ажлын ачаалал үүсэх үндсэн нөхцөл болдог бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь дахин дахин давтагддаг нь ажлын хэт их ачаалал үүсдэг.

Нэг хилийн харуулыг хоёр харуулын дарга хариуцан 7-10 хоногоор ээлжлэн томилогдож хилийн харуулыг удирдан үүрэг гүйцэтгэж байгаа нь алба хаах нийт хугацааны 50 хувьд нь хилийн харуулд ажиллах шаардлагатай болж байгаа юм.

Үүний давтамжийг багасгах зорилгоор нэг хилийн харуулд гурван хилийн харуулын даргыг орон тоогоор томилон 7-10 хоногоор ээлжлэн хилийн харуулыг ахлуулан үүрэг гүйцэтгүүлэх. Ингэснээр тухайн харуулын дарга хилийн харуулыг нэг сард хоёр удаа ахлан үүрэг гүйцэтгэдэг байсан бол нэг удаа л хилийн харуулыг ахлан үүрэг гүйцэтгэж ажлын ачаалал, хүлээх үүрэг хариуцлага 20 хувь буурна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд хилийн харуулын даргын орон тооны хангалт 83.0 хувьтай байгаа бөгөөд хангагдаагүй 17.0 хувийн ачаалал бусад хилийн харуулын дарга нарт нэмэгдэж байгаа энэ үзүүлэлт ч буурах юм.

Хилийн харуулд харуулын дарга, хилийн манаа ахлагч, хилчин гэсэн бүрэлдэхүүнийг томилон үүрэг гүйцэтгүүлдэг бөгөөд харуулын даргын эзгүйд хилийн манааны ахлагч түүнийг орлон ажилладаг. Хилийн манааны ахлагчид хугацаат цэргийн алба хаагч томилогдон өөртэйгээ адил хугацаат цэргийн алба хаагчийг удирдан үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь нэг түвшний алба хаагчид бие

биенээ захирах, захирагдах үед үл ойлголцол, зөрчил дутагдал үүсэх эрсдэлтэй байдаг.

Иймд хилийн харуулын даргын орлогчоор томилох хугацаат цэргийн алба хаагчийг албан ёсоор отрядын даргын тушаалаар томилж тэднийг тусгай сургалтанд хамруулж хугацаат цэргийн алба хаагчаас нэг шат ахиулан цол, эрх мэдлээр ялгах.

Мөн Хил хамгаалах байгууллагад хэрэгжиж буй гэрэт хилчин хөтөлбөрийн хүрээнд гэрээт цэргийн алба хаагчийг хилийн харуулын даргын орлогчийн албан тушаалд томилон үүрэг гүйцэтгүүлэх нэг хувилбар ч болох юм. Ингэснээр гэрээт хилчил нь хилийн харуул удирдах дадлага туршлагатай болж, цаашид ахлагчийн албанд дэвшин ажиллах, Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуульд элсэн суралцах боломж нэмэгдэх болно. Гэрээт цэргийн алба хаагч нь хугацаат цэргийн алба хаагчаас нэг шат дээгүүр албан тушаал тул хилийн харуулын харуулын даргын эзгүйд хариуцлагатай үүрэг гүйцэтгэж, захирах захирагдах ёс хэлбэрэлтгүй хэрэгжиж, хилийн харуулд гарч болзошгүй зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх давуу тал ч бүрдэх юм.

Хилийн харуулын даргын орлогч нь цэргийн албаны зохион байгуулалт, сургалт, дадлага, соёл олон нийтийн ажил, уралдаан тэмцээн, албаны амьтадын арчилгаа малалгаа, ар тал хангалт зэргийг харуулын даргын өмнө биечлэн хариуцаж, түүний үүргийг хуваалцан ажиллах шаардлагатай.

Иймхүү хилийн харуулыг ахлан үүрэг гүйцэтгэж байгаа хилийн харуулын даргын ажил үүргийн хуваарьт тодотголд хийж, харуулын даргын орлогчид тодорхой үүргийг хуваарилах нь ажлын ачааллыг 5 хувиар бууруулах боломж бүрдэнэ.

Дүгнэлт

Хилийн харуулын дарга нарын үүрэг гүйцэтгэлт, ажлын ачаалал их байгаагаас хийж буй ажлаа бүрэн төгс хийдэггүй, зөвхөн өгөгдсөн үүргийг л биелүүлж байгаа нь алба үйл ажиллагаа доголдох, цаашлаад алдаа дутагдал гарах үндэслэл болдог.

Харуулын дарга нарын боловсролын түвшин бага, мэргэшүүлэх болон бусад сургалтад төдийлөн хамрагддаггүйгээс удирдан зохион байгуулах чадвар муу зөвхөн өөрийн туршлагаар ажиллаж байна.

Тэд ажиллах ихэнх хугацааг хилд үүрэг гүйцэтгэж байгаа нь ар гэрийн байдлаа дээшлүүлэх, хүүхдийн сурлага хүмүүжлийн байдалд ч сөргөөр нөлөөлж байгаа тул санхүүгийн байдлыг дэмжих, гэр орон, үр хүүхэддээ зарцуулах боломжийг нэмэгдүүлэх, цэргийн жинхэнэ тэтгэвэрт богино хугацаанд гаргах нь зайлшгүй анхаарах асуудал юм.

Санал

- Хилийн харуулын дарга нарын тоог нэмж нэг хилийн харуулын даргыг сард нэг удаа хилийн харуулд томилон үүрэг гүйцэтгүүлэх;
- Тэднийг дээд боловсролтой болгох, мэргэшсэн харуулын даргын сургалтад хамруулж бэлтгэх;

Эх сурвалжийн жагсаалт

- Хилийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2016 он. №6
- Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 2016 он. №36
- Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Улсын их хурлын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт
- Хил хамгаалалтын дүрэм I, III Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 307 дугаар зарлигийн хавсралт
- П.Даш. Монгол Улсын хилийг харуулаар хамгаалах ажиллагааг боловсронгуй болгох нь. Цэргийн шинжлэх ухааны доктор (Ph.D) зэрэг горилсон бүтээл. Батлан хамгаалах их сургууль, УБ., 2000 он
 - Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн дүрэм. УБ., 2017 он.
 - П.Даш. “Хилийн харуулын дарга” УБ. 1998 он